



ЗАСГИЙН ГАЗРЫН ТОХИРУУЛАГЧ АГЕНТЛАГ
**БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН УЛСЫН ХОРООНЫ
ДАРГЫН ТУШААЛ**

2021 оны 05 сарын 12 өдөр

Дугаар #1114


Улаанбаатар хот

**Биеийн тамир, спортын салбарын
шагналын журам, загвар, маягт батлах тухай**

Монгол Улсын Засгийн газрын Агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, 17 дугаар зүйлийн 17.1 хэсэг, Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Төрийн албан хаагчид шагнал олгох журам”-ын 1.5, 3.2 заалт, 2 дугаар хавсралтаар батлагдсан “Засгийн газрын салбарын тэргүүний ажилтан” хүндэт тэмдгийн төрөл, түүнийг олгох албан тушаалтны жагсаалт”-ын 5 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Биеийн тамир, спортын салбарын шагналын журам”-ыг нэгдүгээр, “Шагналын комиссын бүрэлдэхүүн”-ийг хоёрдугаар, “Засгийн газрын шагнал Биеийн тамир, спортын тэргүүний ажилтан хүндэт тэмдгийн загвар”-ыг гуравдугаар, “Шагналд нэр дэвшигчийн маягтын загвар”-ыг дөрөвдүгээр хавсралтаар тус тус баталсугай.
2. Журмыг баримтлан ажиллахыг аймаг, нийслэл, дүүргийн Биеийн тамир, спортын газрын дарга нарт үүрэг болгосугай.
3. Журмын хэрэгжилтэд хяналт тавин ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын газар /Г.Одбаатар/-т даалгасугай.


ДАРГА



Ц.ШАРАВЖАМЦ

122101206

Биеийн тамир, спортын улсын хорооны даргын 2021 оны 05 дугаар сарын 12-ний өдрийн 111 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт



БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН САЛБАРЫН ШАГНАЛЫН ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1 Биеийн тамир, спортын салбарыг хөгжүүлэх үйлсэд бодитой хувь нэмэр оруулсан, онцгой амжилт гаргасан салбарын албан хаагч, Монгол Улсын болон гадаадын иргэнийг Засгийн газрын /цаашид “салбарын шагнал” гэх/ болон Биеийн тамир спортын улсын хороо /цаашид “хорооны шагнал” гэх/-д нэр дэвшүүлэх, тодорхойлох, шагнал олгохтой холбогдсон харилцааг зохицуулахад энэхүү журмыг мөрдөнө.

1.2 Монгол Улсын цол олгох, төрийн дээд одон, медалиар шагнуулахаар нэр дэвшүүлэхэд энэ журам хамаарахгүй бөгөөд Төрийн дээд одон медалийг Монгол Улсын Ерөнхийлөгчийн 1999 оны 71 дүгээр зарлигийн хавсралтаар батлагдсан журмын дагуу олгоно.

Хоёр. Шагналын ангилал

2.1. Биеийн тамир, спортын салбарын шагнал дор дурдсан төрөлтэй байна.

2.1.1. Засгийн газрын шагнал салбарын тэргүүний ажилтан

2.1.1.1 “Биеийн тамир, спортын тэргүүний ажилтан” хүндэт тэмдэг

2.1.2. Биеийн тамир спортын улсын хорооны шагнал

2.1.2.1. Биеийн тамир, спортын улсын хорооны “Хүндэт дэвтэр”-т бичиж, дурсгалын гэрчилгээ олгох;

2.1.2.2. Биеийн тамир, спортын улсын хорооны “Жуух бичиг”;

Гурав. Шагнал олгох ерөнхий нөхцөл

3.1. Биеийн тамир, спортыг хөгжүүлэх үйлсэд бодитой хувь нэмэр оруулсан, мэргэшлийн өндөр ур чадвартай, онцгой амжилт гаргасан, ажлын амжилт нь хамт олон, мэргэжлийн хүмүүст үнэлэгдсэн, тухайн ажилтны ажлын үр дүн өмнөх түвшнөөс ахисан төрийн албан хаагчид шагналыг байгууллагын, Засгийн газрын гэсэн дарааллаар олгоно.

3.1.1. “Биеийн тамир, спортын тэргүүний ажилтан” (БТСТА);

“Биеийн тамир, спортын тэргүүний ажилтан” тэмдгээр дор дурдсан шаардлагын аль нэгийг хангасан тамирчин, дасгалжуулагч, ажилтан албан хаагчыг шагнана.

3.1.1.1. Биеийн тамир, спортыг хөгжүүлэх үйлсэд бодитой хувь нэмэр оруулсан, мэргэшлийн өндөр ур чадвартай салбартаа 12 жил ажилласан, онцгой амжилт

гаргасан, ажлын амжилт нь хамт олон, салбартаа үнэлэгдсэн, мэргэжлийн боловсон хүчин бэлтгэхэд бодитой хувь нэмэр оруулсан, бэлтгэсэн тамирчид нь улс, олон улсын тэмцээн наадамд өндөр амжилт үзүүлсэн, салбарын жуух бичгээр шагнагдсан багш, дасгалжуулагч, ажилтан албан хаагч;

3.1.1.2. Спортын ур чадвар, үйл ажиллагаа, мэргэшлийн түвшин нь тогтвортой өссөн, олимп, дэлхий, тивийн тэмцээн, наадамд тогтмол амжилт гаргасан, тив, дэлхий, улсын рекордыг шинэчлэн тогтоосон тамирчин;

3.1.1.3. Олимп, тивийн наадам, дэлхийн аварга шалгаруулах тэмцээнд медальт байрт шалгарсан тамирчныг салбарын жуух бичгээр шагнагдсан эсэхийг үл харгалзан;

3.1.2. “Хүндэт дэвтэр”-т нэрийг нь бичиж, дурсгалын гэрчилгээ олгох;

3.1.2.1. Биеийн тамир, спортын улсын хорооны даргын зөвлөлийн хурлын шийдвэрийг үндэслэн Биеийн тамир, спортын салбарыг хөгжүүлэх үйлсэд онцгой хувь нэмэр оруулсан тухайн салбарын хүндтэй эрхэм хүн; /Тухайн шагналд нэр дэвшүүлэхгүй бөгөөд Засгийн газрын тохируулагч агентлаг Биеийн тамир, спортын улсын хорооны даргын санаачлагаар зөвлөлийн хурлаар хэлэлцэн шийдвэрлэнэ.

3.1.3. Биеийн тамир, спортын улсын хорооны шагнал “Жуух бичиг”

3.1.3.1. Салбарын хөгжилд оруулсан хувь нэмэр нь холбогдох мэргэжлийн байгууллага, аймаг, нийслэл, дүүргийн хэмжээнд үнэлэгдсэн Биеийн тамир, спортын салбарт 5-аас доошгүй жил тасралтгүй ажилласан салбарын мэргэжлийн боловсон хүчнийг;

3.1.3.2. Биеийн тамир, спортын салбарт 5-аас доошгүй жил тасралтгүй үр бүтээлтэй ажилласан ажилтан, биеийн тамирын багш;

3.2. Журмын 3.1.1, 3.1.3-ын болзолыг хангасан иргэн, аж ахуйн нэгж, төрийн болон төрийн бус байгууллагын ажилтан, албан хаагч, багш, дасгалжуулагч, тамирчдыг харъяалах анхан шатны байгууллагаас нэр дэвшүүлэн материал ирүүлнэ.

3.3. Өмнө авсан шагналаасаа хойш 5-аас доошгүй жил ажилласан, ажлын амжилт өмнөх түвшнөөс ахисан бол дараагийн шатны шагналд нэр дэвшүүлэх эрх нээгдэнэ.

3.4. Шагналыг Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Төрийн албан хаагчид шагнал олгох журам”-ын 2.5-д зааснаас гадна тухайн салбар байгууллагын ой, тэмдэглэлт өдөр, тамирчдын өдрийг тохиолдуулан тус тус олгоно.

3.5. Онцгой амжилт гаргасан тохиолдолд Засгийн газрын шагналаар шагнахад төрийн албан хаагчийг төрийн албанд ажилласан жилийг харгалзахгүй бөгөөд дараагийн шатны шагналаар шагнаж болно.

3.6. Салбарын шагналд нэр дэвшүүлэгч анхан шатны /нэр дэвшүүлэгчийн ажиллаж байгаа байгууллага, ахмад настан бол үндсэн байгууллага, төрийн болон төрийн бус гэх мэт/ байгууллага нь дор дурдсан баримт бичгийг баяр тэмдэглэлт өдрөөс 45-аас доошгүй хоногийн өмнө Засгийн газрын тохируулагч агентлаг Биеийн тамир, спортын улсын хороонд ирүүлнэ. Үүнд:

- 3.6.1. Шагнуулах тухай хүсэлт гаргасан байгууллагын албан бичиг;
- 3.6.2. Биеийн тамир, спортын улсын хорооны даргын баталсан загварын анкет /цээж зураг, гарын үсэг, тамга, тэмдэгээр баталгаажсан/
- 3.6.3. Хамт олны хурлын тэмдэглэл;
- 3.6.4. Ажил байдлын дэлгэрэнгүй тодорхойлолт, бүтээлийн жагсаалт;
- 3.6.5. Бусад шагналаар шагнагдсан бол тэдгээрийг гэрчлэх үнэмлэхийн хуулбар;
- 3.6.6. Холбогдох материалуудыг цахимаар болон цаасаар ирүүлнэ.

3.7. Шагналд нэр дэвшүүлэх албан хаагч, иргэнийг байгууллагын хамт олны хурлаар хэлэлцэнэ. Хурлын ирц 90-ээс доошгүй хувь байх бөгөөд хуралд оролцогчдын дөрөвний гурваас багагүй нь нэр дэвшүүлэхийг дэмжсэн бол тухайн ажилтан /иргэн/-ы нэрийг дэвшүүлсэнд тооцож, тодорхойлолт гаргана.

3.8. Шагналд нэр дэвшсэн хүний ажил байдлын тодорхойлолтод нийт ажилласан хугацааны ажлын амжилт, үр бүтээл, оруулсан хувь нэмэрийг үнэн зөв, тодорхой бичих ба төрийн албан хаагчийн ёс зүйн байдал, ажил мэргэжлийн ур чадвар, мэргэшлийн түвшний үнэлгээ, амжилтын үзүүлэлт, бүтээлийн жагсаалт, авч байсан шагналын үнэмлэхний хуулбар, журамд заасан холбогдох байгууллагын тодорхойлолт зэрэг холбогдох баримт бичгийг хавсаргасан байна.

3.9. Журамд заасан шаардлагыг бүрэн хангасан, ямар нэгэн байгууллагад харъяалагддаггүй иргэнийг харъяалах, баг хороо төрийн бус байгууллага нь тус тус шагналд тодорхойлно.

Дөрөв. Шагналыг шийдвэрлэх олгох

4.1. Шагналд нэр дэвшигчийн материалыг шагналын асуудал хариуцсан мэргэжилтэн хүлээн авч хянан энэ журмын шаардлагад нийцсэн баримт бичгийг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлнэ.

4.2. Шагналын баримт бичгийн хугацаа хэтрүүлсэн, нэр дэвшигчийн тодорхойлолт дутуу эсвэл хуурамчаар бүрдүүлсэн, журмын шаардлага хангаагүй бол шагнал олгох асуудлыг хэлэлцэхгүй.

4.3. Шагналын баримт бичгийг хуурамчаар бүрдүүлсэн нь нотлогдсон тохиолдолд, нэр дэвшигчийн шагнал олгох асуудлыг 3 жилийн хугацаанд дахин хэлэлцэхгүй.

4.3. Даргын зөвлөлийн хурлаар олонхын санал авсан иргэнд Биеийн тамир, спортын улсын хорооны даргын шийдвэрээр шагнал олгож, шагналыг тодорхойлсон байгууллагад хүлээлгэн өгнө.

Тав. Тэмдэг, үнэмлэхийг нөхөн олгох

5.1. Шагналын тэмдэг, үнэмлэхийг үрэгдүүлсэн тохиолдолд дор дурдсан баримт бичгийг бүрдүүлэн ирүүлнэ.

- 6.1.1. Өргөдөл
- 6.1.2. Иргэний үнэмлэхийн хуулбар
- 6.1.3. Шагналын үнэмлэх, шийдвэрийн хуулбар
- 6.1.4. Мөнгө тушаасан баримт

5.2 Салбарын тэргүүний ажилтны тэмдэг, үнэмлэхийг үрэгдүүлсэн тохиолдолд нөхөн авахад тэмдэгний зардал 20 000 /хорин мянга/ төгрөгийг Биеийн тамир, спортын улсын хорооны санхүүд тушааж баримтыг хавсаргана.

Зургаа. Шагналын мэдээллийн сан

6.1. Монгол Улсын цол, төрийн дээд одон, медаль болон энэ журамд заасан шагналаар шагнагдсан салбарын албан хаагчийн мэдээллийн нэгдсэн сантай байна.

6.2. Салбарын хүний нөөцийн асуудал хариуцсан мэргэжилтэн нь мэдээллийн цахим сангийн бүрдүүлэлт, баяжилт, хөдөлгөөнийг хариуцан хөтөлж хяналт тавина.


Долоо. Дагалдах мөнгөн шагнал

7.1. Засгийн газрын “Биеийн тамир, спортын тэргүүний ажилтан” тэмдгээр шагнахад 150 000 (нэг зуун тавин мянга) төгрөг;

7.2. Шагналын дагалдах мөнгийг тухайн хүнийг шагнуулахаар нэр дэвшүүлж тодорхойлсон /анхан шатны нэгж/ байгууллага олгоно.

7.3. Засгийн газрын болон салбарын шагналаар шагнагдсан гадаадын иргэнд дагалдах мөнгөн шагнал олгохгүй.

Биеийн тамир, спортын улсын хорооны даргын 2021 оны 05 дугаар сарын 12-ний өдрийн 11 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт



БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН УЛСЫН ХОРООНЫ
ШАГНАЛЫН КОМИССЫН БҮРЭЛДЭХҮҮН

Комиссын дарга:

Төрийн захиргааны удирдлагын газрын дарга;

Гишүүд:

Бодлого, төлөвлөлтийн газрын дарга;

Спортын бодлогын хэрэгжилтийн хэлтсийн дарга;

Биеийн тамирын бодлогын хэрэгжилтийн хэлтсийн дарга;


Төрийн захиргааны удирдлагын газрын байгууллагын хүний нөөцийн асуудал хариуцсан мэргэжилтэн;

Нарийн бичиг:

Бодлого төлөвлөлтийн газрын салбарын хүний нөөцийн бодлогын асуудал хариуцсан мэргэжилтэн

---oOo---

Биеийн тамир, спортын улсын хорооны
даргын 2021 оны 05 дугаар сарын 12-ний
өдрийн 11 дугаар тушаалын гуравдугаар
хавсралт



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ШАГНАЛ
БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ТЭРГҮҮНИЙ АЖИЛТАН
ХҮНДЭТ ТЭМДГИЙН ЗАГВАР

“Биеийн тамир, спортын тэргүүний ажилтан” хүндэт тэмдэг нь дараах техникийн тодорхойлолтыг хангасан байна.

Тэмдэг нь /гагнуур тогтохуйц зэс, төмөр/ металл, дүрслэл нь бүхэлдээ алтан шаргал амжилтын тууз бүхий зууван дугуй хэлбэртэй, хоёр талаараа нааш товгор байдалтай амжилтын навч хүрээлнэ. Дунд талын ялалтын бамбар товгор байх ба дүрэлзэн асах галын дөл нь улаан өнгөтэй байна. Арын хэсэг нь мандан бадрахын бэлгэдэл алтан нарны цацраг бүхий товгор дүрс, дээд талын орой хэсэгт хар хөх өнгийн 10мм-ийн диаметртэй дугуй дотор алтан соёмбо байх ба хүрээ нь алтан шар байна. Суурь хэсгийн алтан шаргал туузны дүрс бүхий дэвсгэр дээр хар өнгөөр “Биеийн тамир, спортын тэргүүний ажилтан” гэж Үндэсний /Монгол/ бичгээр бичнэ. Урт нь 40-45мм, өргөн нь 20-22мм, зузаан нь 2-3мм байна. Тэмдгийн ар талд тогтоогч зүүтэй, зүүний доод хэсэгт гялгар металл гадаргуу дээр БТСТА-..... тэмдгийн дугаарыг бичсэн байна.

---oOo---

Биеийн тамир, спортын улсын хорооны даргын 2021 оны 05 дугаар сарын 12 ний өдрийн 111 дугаар тушаалын дөрөвдүгээр хавсралт



ШАГНАЛД НЭР ДЭВШҮҮЛЭХ АЖИЛТНЫ МАЯГТ

1. Овог:
2. Нэр:
3. Регистрийн дугаар:
4. Нас:
5. Хүйс:
6. Яс үндэс:
7. Бүртгэлтэй хаяг:
8. Ажлын газрын үндсэн захиргаа:
9. Боловсрол, мэргэжил эзэмшсэн байдал /он дарааллаар/
10. Ажил эрхэлсэн байдал /он дарааллаар/

3x4 зураг

№	Ажлын газрын нэр	Ажилласан хугацаа /он, сараар/	Эрхэлсэн ажил албан тушаал
1			
2			
3			
4			

11. Нийт ажилласан жил:
12. Үүнээс тухайн салбарт ажилласан жил:
13. Шагнагдаж байсан шагналууд /он цагийн дараалал баримтлан бичих бөгөөд шагналын хуулбарыг заавал хавсаргана./

№	Шагналын нэр	Шагнал, үнэмлэхийн дугаар	Шагнагдсан он
1			
2			

14. Шагнуулах үндэслэл: /Товч, тодорхой бичнэ/

.....

.....

.....

.....

.....

15. Ямар шагналд нэр дэвшүүлсэн:

.....

16. Хамт олны саналын хувь:

17. Шагналыг хүлээн авах /байгууллагын/ хариуцсан ажилтны нэр, утасны дугаар:

.....

.....

----OOO----